



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Босго шугам тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 63 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр бэлэн мөнгө хэлбэрээр хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох өрхийн амьжиргааны түвшний үнэлгээний босго шугамыг 670 болон түүнээс доош оноогоор тогтоосугай.

2. Энэхүү босго шугамын нөхцөлийг хангасан 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцон хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох ажлыг зохион байгуулан ажиллахыг Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/-т, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Босго оноо тогтоох тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ

